



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар A/615

Ховд

Г  
Х.Манатад сахилгын шийтгэл ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны A/584 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтээр Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Х.Манат нь Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2, 20.2.7, Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 5 дугаар тогтоолууд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны A/243 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм”-ийн 4.2, 4.3.5, 4.3.6, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны A/491 дүгээр тушаал зэрэг хууль тогтоомжуудыг зөрчсөн нь нотлогдож байгаа тул албан тушаалын цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 15 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Сахилгын шийтгэлийг хэрэгжүүлж ажиллахыг тус сургуулийн нягтлан бодогч Х.Бүлдиршинд зөвшөөрсүгэй.

3. Сургуулийн хамт олны төлөөллийн сургалтын менежер Я.Өмнрханд гаргасан гомдол нь ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тул хариуцлага тооцон, хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгож, хамт олныг тэгш хүртээмжтэй удирдлагаар хангаж, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллахыг Х.Манатад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/615 Ch  
02 03052